

December 26, 1962

**Memorandum of conversation, Mongolian Prime
Minister Yumjaagiin Tsendenbal and Chinese Prime
Minister Zhou Enlai**

Citation:

"Memorandum of conversation, Mongolian Prime Minister Yumjaagiin Tsendenbal and Chinese Prime Minister Zhou Enlai", December 26, 1962, Wilson Center Digital Archive, Mongolian Foreign Ministry archive: fond 5, dans 1, kh/n 283. Obtained by Sergey Radchenko. <https://digitalarchive.umd.edu/document/134679>

Summary:

Discussion of Sino-Mongolian economic relations and the Sino-Indian border war.

Original Language:

Mongolian

Contents:

Original Scan

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НӨХӨР
Ю.ЦЭДЭНБАЛД БНХАУ-ЫН ТӨРИЙН ЗӨВ-
ЛӨЛИЙН ЕРӨНХИЙ САЙД НӨХӨР ЧЖОУ-
ЭНЬ-ЛАЙ БАРААЛХАЖ УУЛЗСАН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ

1962 оны 12 дугаар сарын 26-ны өдөр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий Сайд нөхөр Чжоу Энх-лай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Ю.Цэдэнбалд хариу бараалхав.

Энэ уулзалт II цагаас 14 цаг хүртэл нөхөр Цэдэнбалын буусан байранд болов. Уулаалтанд монголын талаас нөхөр Цэдэнбалыг дагалдан яваа Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Жагварал, Гадаад Явдлын Яамны Сайд Шагдарсүрэн, мөн орлогч сайд Сосорбарам, Элчин сайд Цэвэгмид, депутат С.Батаа, Гадаад Яамны нэгдүгээр хэлтсийн эрхлэгч Чимэддорж нар байлцав.

Уулзалтанд Хятадын талаас: Төрийн Зөвлөлийн Ерөнхий Сайдын орлогч бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад Яамны сайд Чень-И, Гадаад яамны орлогч сайд Цэн Пен-фей, Гадаад яамны Азийн хоёрдугаар хэлтсийн дарга Чжоу Чю-е, протоколын хэлтсийн дарга Юй Пэй-вэнь, БНХАУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд Се Фу-шен нар байлцав.

Хятадын талаас орчуулагч Эрдэнэбулга орчуулав. Манай орчуулагч Адьяа байлцав. Мөн Хятадын Гадаад яамны ажилтан Гэгээнхүү болон өөр нэг ажилтан тэмдэглэл хийж байв.

Эхлээд зочдыг хүлээн авч, цай, жимс, тамхиар зочилж протоколын чанартай яриа эхлэн зураг авсны дараагаар тусгай бэлтгэсэн тасалгаанд шилжиж 3 цаг үргэлжлэн ярилцав.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Чжоу Энх-лай, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Цэдэнбал нарын яриаг тэмдэглэхэд:

Чжоу Энх-лай- Дарга Цэдэнбал Та манай сронд морилон ирж, манай хоёр улсын хилийн тухай гэрээнд үсэг

зурах болсон явдалд бид баяртай байна. Энэ бол хоёр улсын найрамдалт хилийг хуулиар батагах сайн талтай хэрэг юм.

Өчигдөр Цэдэнбал таны хэлснээр хилийн гэрээ байгуулах нь найрамдлыг, энх тайвны хэрэгт чухал ач холбогдолтой зүйл юм.

Хятад, Монгол хоёр улс хилийнхээ асуудлыг зохистойгоор шийдвэрлэсэн нь бусад улсуудтай хилийн талаар ярилцахад түлхэц болох бөгөөд үлгэр жишээ болох юм.

Бид Солонгостой хилийн асуудлаа үндсэнд нь хэлэлцэн тохирч шийдвэрлэсэн, харин Солонгосын хариуг хүлээгээд, энэ тухай хэвлэлд нийтлээгүй байна.

Хятад-Монгол, Хятад-Солонгосын хилийн асуудал нэгэнт шийдвэрлэгдэж байгаа болохоор ярилцсан ^{эрэнхийт} зарчмын ёсоор бид цаашдаа хилийн шугамыг газар дээр нь тогтоон тэмдэглэх хамтарсан комиссыг байгуулж гүйцэтгэх болно.

Одоо манай улс хилийн шугамыг газар дээр нь тодотгон тэмдэглэх тухай асуудлаар Бирма, Балба улсуудтай ярилцаж байна. Эдгээр улстай энэ асуудлыг санал нэгтэй шийдвэрлэх боломжтой байгаа юм. Ингэж албан ёсоор хилээ тодотгон тогтоох болно. Хятад, Монголын хооронд байгуулж байгаа хилийн гэрээ нь манай айл хөрш орнуудтай хилийн тухай асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болно.

Хятад нь саяхнаас Пакистантай хилийн хэлэлцээ хийж эхлэв. Үүнд удахгүй тохирох болов уу гэж үзэж байна. Энэ талаар Пакистантай ярилцаж байгаа байдал сайн байна. Хилийн тухай асуудал бол Кашмирын асуудалтай холбогдолтой. Энэ бол Пакистан, Энэтхэгийн

асуудал юм. Хятад, Пакистаны хилийн хэлэлцээ дуусахын хамт түр зуурын протокол байгуулна. Харин албан ёсны гэрээ байгуулах ажлыг Энэтхэг, Пакистаны хооронд Кашмирын асуудал шийдвэрлэсний дараа гүйцэтгэнэ.

Ер нь манай хилийн гэрээ нь бодит үнэн байдлыг тусган харуулах болно.

Бид өнөөдөр Хятад, Пакистаны хилийг албан ёсоор тогтоосхгүй, Энэ бол Энэтхэгийг мадалж байгаа хэрэг. Энэтхэг Пакистан хоёрын хил албан ёсоор тогтоогүй байсан хэвээрээ л байна.

1959 онд нөхөр Цэдэнбал Таныг Энэтхэгт айлчлах үеэр хилийн асуудал ид яригдаж байсан билээ. Тэхэд би, Хятад-Энэтхэгийн хилийн тухай Танд танилцуулж байсан боловч Та Энэтхэгт очихдоо энэ асуудлаас зайлсхийх гэм оролдоод байсан удаа бий. Үүнийг бид их сонирхдог юм.

Энэтхэг, Пакистаны хооронд Кашмирын асуудлаар хилийн будлиан ихтэй байна. Бас манай хилийн баруун хэсэг Аксай, Төвдийн Алийн район Энэтхэгтэй хил нийлж буй. Энэ бол түүхийн уламжлалт шугам байсан юм.

Пакистан хилийн тухай асуудлаар зөв хандлагатай байна. Кашмир хэнд хамаарах нь шийдсэний дараа манай хоёр улсын хилийн гэрээ байгуулах нь зайлшгүй. Гэвч Энэтхэг түүнийг аль болохоор эсэргүүцэхийг хүсэж байгаа боловч тэр нь үндэсгүй юм. Хятад, Пакистаны хилийн тухай Өрнөдийн орнууд ба Английн сонин олон удсын хэв журамд нийцэж буй зөв асуудал гэж үзэж бичиж байна.

Харин энэ асуудлын хувьд америкийн харгис этгээдүүд зэвүүцэн сандарч буй бололтой. Хэрэв Хятад, Пакистан, Энэтхэг улсууд хилийн талаар

аятайхан хэлэлцэж тохирох юм бол Америк мэтийн империалист улсуудаас Азид явуулах түрэмгийллийн бодлогод саадыг учруулж цохилт болох юм гэж үзэж байна. Энэ талаар Америкийнхан айж байгаа бололтой, Хятад Пакистаны хилийн асуудлыг шийдэх, Хятад Энэтхэгийн хилийн асуудлыг шийдэхэд хүрвэл тэдний түрэмгийлэлд саад болох байх гэж тэд бодож байна. Сүүлийн үед Америкийнхан Энэтхэг, Пакистаныг аль болохоор хавчиж, Кашмирын асуудлыг түргэн шийд гэж шаардаж байна. Ойрын үед Энэтхэг, Пакистаны хилийн хэлэлцээ сайд нарын хэмжээнд эхлэх гэнэ. Английнхан Кашмирыг хоёр талын мэдэлд байлгах буюу Пакистаныг Энэтхэгийн холбосны улсад байлгах ийм асуудал тавих гэж байна. Бидний бодоход Энэтхэг, Пакистаны хилийн хэлэлцээ сайн үр дүнд хүрч чадахгүй байх аа. Неру Америкаар Энэтхэг, Пакистаныг ноёрхуулах арга замыг эрж байна. Өөр замгүй байгаа бололтой, Хэрэв тиймд хүрвэл байдал хүндэрч асуудлыг Энэтхэгийн ард түмэнд тайлбарлахад хэцүү болох юм.

Хятад, Энэтхэгийн хилийн асуудлаар бид тодорхой дурдсан захидлыг Ази Африкийн орнуудад илгээсэн билээ. Дарга Цэдэнбал Танд ч өгсөн. Энэтхэг 1961 оноос эхлэн манай хил рүү түрэн нэвтэрч хилийн 43 заставыг байгуулжээ. Яригдаж байгаа тэр район бол хүйтэн, цастай, уулархаг район юм. Хятад, Энэтхэгийн хилийн будлиан үүсч, Энэтхэг тасралтгүй түрэн довтолсон болохоор бид тэсвэрлэх аргагүй болж, Энэтхэгт эсрэг цохилт өгөөд дээр дурдсан 43 заставыг цэвэрлэсэн билээ. Зарим нь манай хүчинд дарагдаж, тэр районыг цэвэрлэсэн байна. Манай засгийн газар гал зогсоож, цэргийн отрядыг 20 км ухруулан татаж шийдвэрийг II дүгээр сарын 21-нд гаргалаа. 20 км өргөн хүнгүй хяналтын газар бий болгоё гэсэн. Хилийн будлиан болсон энэ

районд урьд нь манай цэрэг байгаагүй юм.

Мөн хилийн байр харуул ч байгаагүй, зөвхөн хилийн эргүүл гаргах байлаа. Харин засаг захиргааны хувьд бид захирч байсан юм. 1959 оноос хойш Энэтхэгийнхэн тэр рүү өнгөлзөж, довтолгоо хийсэн. Тэднийг цэвэрлэсний дараа тэр газар манай тийм хилийн харуул байхгүй. Хэрэв ийм байдалд Энэтхэг манай хил рүү дахин довтолбол ёстой гүтгэлэг халдлага болох юм.

Хэрэв Энэтхэг Кашмирыг Пакистанд өгөөд манай Аксайн газрыг авахыг дахин оролдвол Энэтхэг нь ёстой л америкийн мэдэл, тэдний заалтаар ажиллаж байгааг гэрчилэх болно. Тийм үр шимтэй, ургац сайтай Кашмирыг Пакистанд өгөөд ямар ч хүн амьтангүй, үр ашиггүй газрыг авах гэж байгаа нь тэдний харгис чанарыг харуулж байна. Ийм нөхцөлд бид гал зогсоов. Цэргээ гэдрэг татав. Манай бодлого ба арга хэмжээг Ази, Африкийн ард түмэн, дэлхийн энх тайвныг эрхэмлэгч ард түмэн дэмжиж байна. Түүнчлэн танай засгийн газар манай мэдэгдлийг талархасанд бид талархлаа илэрхийлье. Одоогоор Энэтхэг хэцүү байдалд орлоо. Манай саналыг Ази, Африкийн орнууд дэмжиж байгаа юм. Энэ нь Энэтхэгийг улам арчаагүй байдалд оруулж байна. Саяхан Коломбод Энэтхэг-хятадын хилийн тухай хэдэн орны удирдах хүмүүс саналаа солилцон ярилцаад дүнгээ танилцуулахаар манай улсад Цейлоны ерөнхий сайдыг ирүүлэхээр томилжээ.

Тэгээд 12 дугаар сарын 31-нд ирэхээр болжээ. Урьдчилан бэлтгэл асуудлаар тусгай хүн ирсэн. Эдгээр улсууд нь Энэтхэг Хятадыг эвлэрүүлэх бодлоготой, гал зогсоосныг бататгах хэлэлцээ эхлүүлэх санаатай байна. Хэрэв тийм бол бид бэлхэн байна. Хамгийн гол нь хоёр талаас мөргөлдөөн гаргахгүй байхыг эрмэлзэх явдал мөн. Энэ бол манай гол бодлого юм. Хятад Пакистаны асуудал идэвхтэй

яригдаж байхад Хятад-Энэтхэгийн асуудал яагаад болохгүй байна гэж зарим улс асууж байна. Пакистан хэдийгээр эвсэл холбоонд орсон улс боловч Америк, Английн үгэнд оролгүй, бидэнтэй хэлэлцээ хийх гэж байна.

Гэтэл Энэтхэг өөрийгөө түрэмгийлэлийн эвсэлд ороогүй гэдэг боловч хэрэг дээрээ Америкийн үгээр ярьдаг улс болжээ.

Цэдэнбал-Энэтхэгийг танайх төвийг сахисан улс гэж үзэж байна уу, үгүй юу?

Чжоу Эн-лай-Энэтхэг төвийг сахисан гэдгээсээ ухарч байгаа юм.

Хятад, Афганистаны хооронд хилийн жижиг асуудал бий. Бид удахгүй, энэ тухай хэлэлцээ эхлэнэ.

Манай улс социалист орнууд ба Азийн шинэ улсуудтай ч гэсэн түүхэнд үлдэж ирсэн асуудлыг эв найрамдал, хэлэлцээний замаар шийдвэрлэж болохыг туршлага гэрчилж байна. Хятад-Монголын хилийн тухай гэрээ үүнийг мөн үзүүлж байна. Манай хоёр улс бол социалист орон юм. Хилийн асуудлыг найрамдал тэгш эрх, харилцан ойлгох, харилцан найр тавих, зарчмаар түргэн хугацаанд эв шийдвэрлэв. Хилийн асуудал хэлэлцсэн манай хоёр улсын засгийн газрын төлөөлөгчид амжилттай ажиллажээ.

Хилийн тухай гэрээнд үсэг зурахад бэдэн болжээ. Цаашдаа хилийн шугамыг газар дээр нь тогтоон тэмдэглэх хамтарсан комисс байгуулан ажиллуулах болно.

Цэдэнбал-Ерөнхий сайд Чжоу Эн-лай Та хятадтай хил нийлсэн улсуудтай хилийн хэлэлцээ хийж байгаа байдал, энэ талаар тавьж байгаа бодлогоо танилцуулсан явдалд талархал илэрхийлье.

Манай хоёр улсын хилийн шугамыг тодотгож тогтоох ажил амжилттай дуусч, гэрээнд үсэг зурахад бэлэн болжээ. Манай хоёр улсын засгийн газрын төлөөлөгчид хилийн тухай хэлэлцээг харилцан биесийн ашгийг харгалзах, харилцан ойлгох, харилцан найр тавих, харилцан хүндэтгэх үндсэн дээр амжилттай хийсэн нь зөв болсныг ерөнхий сайд танаас тэмдэглэж ярьсан нь зүйтэй байна. Би бас Таны нэгэн адил тэгж бодож байна.

Социалист орнууд бол нэг зорилготой, нэг үзэл сурталтай болохоор ямар нэгэн асуудлыг найрамдлын замаар шийдвэрлэж байх нь зайлшгүй юм. Энэ үндсэн дээр ч манай хоёр улсын хилийн асуудал шийдвэрлэгдэж байна.

Социализм, коммунизм байгуулж байгаа ард түмний зорилго, мөлжих нийгмийн бий болгосон хил хязгаар мэт үндэстнийг хооронд нь салгаж тусгаарласан ийм элдэв зүйлүүдийг ирээдүйд устгаж арилгахад орших юм. Гэвч одоогоор хил хязгаар хэвээрээ байх хэрэгтэй л зүйл юм. Энэ зүйлийг би зөвхөн коммунизмын эцсийн зорилгын үүндээс ярьж байна.

Чжоу Энх-лай-Хятадын зүйр үгэнд эцсийн эцэст ертөнц цом адил болно, мөлжих мөлжигдөх ёс устах тухай чухал зэвүүн байдаг. Гэвч бүх дэлхийгээр нэгдэхийн өмнө хилийн шугамаа тогтоож, ажил хөгжлөө бодох нь ч зүйтэй юм даа.

Цэдэнбал-Улс үндэстэн тусгаар тогтнолоо улам бататгаж өөрийн орныг хөгжүүлэн, үүгээр дамжин цаацдаа коммунизмын байгуулалтанд орох болно. Юмны диалектик ийм юм.

Чжоу Энх-лай-Энэ бол хэлын ирээдүйн чиглэлийн асуудал биз дээ.

Цэдэнбал-

Тийм ээ тийм, Хятад-Энэтхэгийн хилийн талаар будлиан гарсан явдалд манай засгийн газар, ард түмэн гүнээ харамсаж байдаг бөгөөд энэ асуудал энх тайвнаар шийдвэрлэгдэнэ гэж итгэж, тэгж шийдвэрлэгдээсэй гэж бодож байдаг. Ийм ч бодлого бид өр нь баримталж байдаг. Азийн хоёр их гүрний хооронд ямар нэгэн будлиан гарч найрамдал эвдрэхэд хүрвэл уул хоёр орны ард түмэнд ч, энх тайвныг сахихад ч гэсэн ашигтай биш юм аа.

1959 онд биднийг ЭнэтхэгТочих үеэр хилийн тухай асуудал хурцдаж байсан. Тэр цагаар манай айлчлал тохиолдсон юм. Тэр үеийн байдлыг ерөнхий сайд Та надад танилцуулж байсан удаа бий. Биднийг Энэтхэгийн нутагт анх очих үед сонин сурвалжлагчид энэ будлианы тухай асуудал тавьсан. Тэхэд нь хоёр их гүрэн энэ асуудлаа эв найрамдлаар шийдвэрлэнэ гэдэгт итгэж байна гэж бид хариу өгсөн юм.

Би Неру-тэй уулзахдаа, сонин сурвалжлагчид ийм асуудал тавьж байна. Хилийн тухай асуудлыг хоёр улс найрамдлаар шийдвэрлэнэ байх гэж санаа байна гэдгээ хэлсэн юм. Тэр үед гол нь хилийн шугамын зүүн хэсгийн 90 мянган хавтгай дөрвөлж км газрын тухай л яригдаж байсан байх аа. Неру хэлэхдээ, хилийн шугамын дагуу нэг хоёр км газар бол өгч аваад, тохирч болох асуудал юм. 90 мянган хавтгай дөрвөлжин км газар оршин суугчид нь Энэтхэгийн харъяанд байгаа бөгөөд тэндэхийн оршин суугчдын төлөөлөгчид Энэтхэгийн их хуралд сонгогдсон байдаг. Ийм болсоор асуудлыг шийдвэрлэхэд хэцүү юм гэж байв.

Үнэхээр ч тийм хэмжээний нутаг дэвсгэрийн талбайн асуудлыг шийдвэрлэхэд хялбар оус гэж

бодож байна. Нилээд удаан хугацаанд шийдэх асуудал байлгүй дээ.

Энэ жил гарсан хилийн будлиан, зэвсэгт мөргөлдөөн нь байдлыг нилээд хурцатгасан байна. Одоо бол тэр үед тавигдаж байсан районоос илүү газрын тухай ч яригдаж байгаа юм шиг байна. Энэ асуудлын хувьд Хятадын засгийн газар нэг талаас санаачилж гал зогсоосон явдал бол олон талын зүйлүүдийг анхаарч харгалзан бодсон ухаалаг алхам боллоо гэж бид үзэж байна. Хятад-Энэтхэгийн хилийн будлианыг энх тайвнаар, хэлэлцээний журмаар шийдвэрлэхэд танай талаас уян хатан арга хэмжээ авч байгаа гэж бид үзэж байна. Ер нь олон улсын хоорондын харилцааны асуудлыг шийдвэрлэхэд уян хатан бодлого хэрэглэх нь чухал болохыг амьдрал одөр тутам харуулж байна.

Энэтхэг-Хятадын хилийн асуудлыг энх тайвнаар шийдвэрлэгдэнэ гэдэгт бид эргэлзэхгүй байна. Хятад, Энэтхэгийн хилийн будлианыг ашиглаж, Энэтхэгийн дотоодод харгис хүчин их идэвхиж, коммунист нам, ардчиллын хүчийг довтолох явдал их хүчтэй болжээ. Танай засгийн газар Энэтхэг, Хятадын хил дээр гал зогсоож, хилийн отрядуудаа гэдрэг татаж, цаашид энэ асуудлыг хэлэлцээний журмаар шийдвэрлэхээр авч буй арга хэмжээ сайн үр дүнд хүрнэ гэж бид итгэж байна. Энэ бол нэг талаар Энэтхэгийн дотоод дахь харгис хүчинд цохилт өх, нөгөө талаар Америк тэргүүтэй империализмын харгис хүчинд цохилт өгч чадах юм гэж үзэж байна. Бас иймэрхүү арга хэмжээ нь Энэтхэгийг төвийг сахих байрнаас нь буулгахгүй, тэр байранд нь бэхжүүлэх арга хэмжээ болно гэж үзэж болох байна. Энэ бол дэлхий дахины энх тайвныг хамгаалах тэмцэлд тус дөхөм болох юм. Америкийн империалистууд үнэхээр энэ будлианыг

ашиглаж, өөртөө ашиг олохыг оролдож байгаа юм. Харин асуудлыг энх тайвнаар шийдвэрлэвэл Америкийн империализмд сүрхий цохилт болох нь зайлшгүй юм.

Манай хоёр улс хилийн тухай гэрээ байгуулсны дараагаар хилийн шугамыг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажилд шилжин орно. Хэлэлцээний үед Монголын баруун хязгаар дахь Баян-өлгий аймгийн районд байгаа Хуримт гэдэг газрын тухай манай тал асуудал тавьсан билээ. Тэнд манай нутгийн ардууд зарим барилга барьсан бөгөөд мөн ой мод ашиглах ажлыг хийдэг юм байна. Гэтэл танай тал энэ нутгийг Монголд хамааруулах боломжгүй, бэрхшээлтэй байна гэжээ. Хоёр талын орон нутгийн ардууд харилцан ойлгож, тэндэх ой модыг ашиглах ажлыг зохистой шийдвэрлэж болно гэж танай тал хариу өгсөн байна. Ийм учраас Хуримтын тус газрыг монголын хилд заавал оруулж өгнө үү гэж асуудлыг дахин тавихаа больё. гэж бодож байна. Энэ ч яахав, бид харилцан нэг нэгийнхээ ашгийг харгалзах зарчмаар шийдэж болно гэж бодож байна. Харин танай тал тэнд байгаа манай байшин барилга болон тэр нутгийн ой модыг ашиглахад бололцоо өгнө гэсэн явдалд бид баяртай байна. Тэр нутгийн хавьд өөр мод авах газаргүй учраас ийм асуудал гарсан байжээ. Энэ бол найрамдал харилцан ойлгох замаар шийдэж болох асуудал юм.

БНХАУ байгуулагдсанаас хойш эх дүүнийн найрамдалт харилцааны үндсэн дээр ган зудын үед түр зуурын бэрхшээл тохиолдоход хоёр улс талын нутгийн зарим районы айл өрхүүд харилцан билчээр ашиглах бололцоог нэг нэгэндээ тавьж өгсөөр ирсэн сайхан заншилтай. Хэрэв цаашдаа ч бэрхшээл тохиолдвол

-24-

II

заншил болсон тэр сайхан туршлагаа үргэлжлүүлэх бололцоотой гэж найдаж байна. Энэ тухай манай мал хөдөө аж ахуй эрхэлсэн газрын эзэн помещик нөхөр Жагварал нилээд сонирхолтой байдаг байх аа / гэж тоглоомын байдлаар хэлэв/

Зарим бэрхшээлтэй үед ялангуяа өвөл, хавар, манай аймаг, сумын малчдын малд билчээр тавин өгч туслаж байсан явдалд та бүхэнд талархлаа илэрхийлье. Манай хоёр улсын хилийн тухай асуудлыг богино хугацаанд шийдвэрлэсэн явдалд бид нэгэн адил сэтгэл хангамжтай байна.

Үүнээс гадна, Ерөнхий сайд Тантай уулзсан завшаанд хоёруу^{жижиг} асуудал ярихыг хүсэж байна. БНХАУ, манай улсын бүрэн байгуулалтын хэрэгт эдийн засаг, санхүү, мэрэгжилтэй ажилчны хүчээр туслаж байгаа явдалд бид талархалтай байдаг бөгөөд одоо ч талархлаа илэрхийлж байна. Хоёр засгийн газрын хооронд урьд байгуулагдсан хэлэлцээрүүдийн үндсэн дээр баригдах зүйлүүдийн хувьд гэвэл манай хоёр талын зохих байгууллагууд хоорондоо хэлэлцээ хийж байна. Цаашид энэ хэлэлцээгээ үргэлжлүүлэх байх аа. Бид Танаас хүсэх зүйл бол:

1. Төмөр замаар тээвэрлэх ачаа бараа, сүүлийн жилд нилээд хэмжээгээр хорогдсон, Үүнд танайд ган гачиг болсон явдал нөлөөлсөн байж болох юм. Цаашид төмөр замаар тээвэрлэх ачааг нэмэгдүүлэхийг хүсч байна. 1952 онд Ерөнхий сайд та бид хоёр Зөвлөлтийн нөхөдтэй хамтран хийсэн гурван талын хэлэлцээр ёсоор байгуулагдсан төмөр замыг дүүрэн ашиглах нь манай улсад эдийн засгийн талаар ашигтай байна. Энэ талаар Таныг анхаарах болов уу гэж итгэж байна.

2. Танайхаас манайд үзүүлж байгаа тусламжийн нэг хэлбэр бол зохих мэрэгжлийн ажилчныг өгч байгаа явдал мөн. Ажлын энэ хүч нь манай орны бүтээн

байгуулах хэрэгт их тусыг хүргэж байна. Гэвч зарим нэг учир сайн ойлгохгүй, ухамсар дутагдалтай хүмүүсийн зүгээс ажил хаях явдал сүүлийн үед гаргадаг боллоо. Энэ тухай мэдээ та бүхний сонорт хүрсэн болов уу гэж бодож байна. Манай талд ч дутагдалтай зүйл бий. Зарим үед ажилчдыг үйлдвэрлэлийн материалаар цаг тухайд нь хангаж өхгүй зэрэг өөр зарим жижиг сажиг дутагдал гардаг байлаа. Урьд нь хоёр талаасаа харилцан ойлгоцож хамтран ажиллаж, асуудлыг арга зүйгээр нь шийдвэрлэсээр ирсэн билээ. Гэтэл сүүлийн үед зарим газруудад группээр ажил хаях явдал гардаг боллоо. Танай Элчин Сайдын Яамны зүгээс арга хэмжээ авсны үрээр тийм зохисгүй явдал гарах нь одоо бараг тасраад байна. Бид цаашдаа хятад ажилчны хэргийг эрхлэх газар болон, Хятадын Элчин Сайдын Яамтай хамтран ажил зохиож дутагдлыг засах ажил хийнэ гэж бодож байна. Тийм дутагдал дахин гарахгүй байх аа гэдэгт итгэж байна. Танай зарим хүмүүс ярихдаа манай хятад оронд ажил хаяхыг зөвшөөрсөн байдаг гэж ярьдаг. Энэ бол буруу ойлгож ярьж байгаа хэрэг байх даа. Юу ч гэсэн ажил хаях явдал бага болж байна. Бид Хятад нөхдийн тусламжтайгаар хятад ажилчдыг ажиллуулж, тэдний тусламжийг олигтой ашиглаж үр дүн гаргах нь зайлшгүй юм. Манай талаас ажилчдын дунд хүмүүжил, ухуулга таниулгын ажлыг зохиож чадахгүй байна. Энэ талаар хөл мэдэхгүй, тэр бүр орчуулагч хүрэлцэхгүй явдал байдаг.

Манайд одоо ажлын хүчний хэрэгцээ их байна. Танай улс хүн амаа олшруулах нь чухал гэж нөхөр Чжоу Энх-лай Та өчигдөр хэлж байсан. Ажилчдыг сайн ашиглахыг Та удаа дараа зөвлөж байсныг

-28-

18

санаж байна. Бид цаашдаа хэлэлцээрт тодорхойлсон тооноос дутагдах ажилчнаа нөхөж авах санаатай. Энэ талаар манай зохих байгууллага танай холбогдох байгууллагдагатай харилцан гүйцэтгэх болно. Харин нөхөж авах ажилчны тоонд хэл мэдэхийг бодож, өвөр монголчуудаас оролцуулж өгсөн ч бид татгалзахгүй.

Энэ асуудлыг бид үндсэрхэх үзэл с гаргаж тавьж байгаа хэрэг биш юм. Бид үнэн хэрэгцээгээ хэлж байна. Манай Намын Төв Хороо, хэдэн жилийн өмнө монголчуудыг манай улсад шилжүүлэн өгнө үү гэж Танай Намын Төв Хороонд захидал бичсэн юм. Түүнд хэдэн зуун мянган монголчуудыг өгнө үү гэж дурдсан юм. Та үүнийг мэдэж байгаа байх аа. Гэтэл энэ талаар тухайн үед харин өхдөө монголчуудыг шилжүүлэх боломжгүй, харин цөөн тооны хэлмэрч өгч болно гэж байсан билээ. Бодвол танай улсад зохих бэрхшээл буюу онцлог шалтгаан байсан байж дээ. Тийм шалтгаан байна гэдгийг бид олж хараагүй. Бид дээр хэлсэн ёсоор үндсэрхэх үзэл гаргаж байгаа биш гэдгийг ойлгох болов уу гэж итгэж байна.

Танай хятад ажилчид муу ажиллаж байгаа юм уу, тэдгээрийг бид голж байгаагаас энэ тухай асуудлыг ярьж байгаа хэрэг биш гэдгийг зөв ойлгоно байх аа гэж Танаас хүсэх байна.

Харин Хятадын олон муж нутгуудаас манай оронд очсон ажилчид, манай байгалийн хүнд нөхцөл бэрхшээлийг даван туулж тэсвэртэй ажиллаж байна. Энэ бол сайхан хэргээ.

3) — 1963 оны манай хоёр улсын худалдааны хэлэлцээ эхлэн явагдаж байна. Манай хоёр талаас харилцан нийлүүлэх барааны хувьд бололцоогоо судалж боловсруулан шийдвэрлэж чадаагүй асуудлууд аль

-28-

14

алъ талдаа байна. Үүнийг боловсруулж хариу охдөө манай хэрэгцээний барааг хангах талаар анхаарч өгвөл сайн байна гэж Ерөнхий Сайд Танаас хүсэх байна. Танай нөхөд манай улснас худалдаагаар өх адууны тоог нэмэгдүүлэхийг хүссэн байна. Бид адууг нэмж өх бололцоотой гэж үзэж байна. Үүнийг Танд мэдэгдье.

Ерөнхий сайд Танаас энэ уулзалтан дээр чухал зүйлүүдийг ярьж танилцуулсан явдалд дахин талархалаа илэрхийлье.

Чжоу Энъ-лай-Дарга Цэдэнбал Та гурван асуудлыг тавилаа. Та Хятад-Монголын хилийн тухай асуудал зохиостой шийдвэрлэгдсэнийг өндрөөр үнэлж байна. Би үүнийг дүүрэн зөвшөөрч байна. Хилийн баруун хэсэгт байгаа нэг хэсэг газрын тухай Та ярилаа. Энэ бол одоогийн хилийн гэрээнд хамаарагдахгүй асуудал юм. Харин Монголын талын эдийн засгийн ашиг сонирхлыг бодож, дараа ажлын журмаар шийдвэрлэж болох юм. Ган зудын бэрхшээл тохиолдвол харилцан хоёр талдаа туслалцах нь зүйтэй. Бид хоёр талдаа ямар нэгэн бэрхшээлтэй үед туслалцаж ч байсан юм. Энэ бол манай хилийн дагуу оршин суугчдын уламжлалт заншил юм. Энэ талаар Та сэтгэл зовох хэрэггүй. Бид ах дүү ёсоор харилцан гүйцэтгэх болно.

Цэдэнбал- Танай малчдад ч тийм шаардлага гарвал бид тухайн үед тусалж байх болно. Ийм туршлага ч бий.

Чжоу Энъ-лай-Хятадаас монголд үзүүлэх эдийн засгийн тусламжийн тухайд гэвэл, ажилчины хүчээр туслах, бүтээн байгуулах барилгын ажил, худалдааны тухай, төмөр замын тээврийн тухай, эдгээр тодорхой асуудлын талаар өнөөдөр ярихад цаг давчуу байна.

-28-

15

+ Иймд маргааш үдээс хойш цаг гаргаж ярилцаж,
Хятад-Энэтхэгийн хилийн будлианы талаар
 Таны харамсалтай гэж хэлсэн үг ойлгогдохгүй
 байна. Энэтхэгийн тухай хэлж байгаа бол зүйтэй.
 Харин Хятадад хамааруулж буруутан болгох гэж
 байгаа бол эвгүй юм. Энэ асуудлаар манай ах дүү
 орнуудын хооронд маргаан бий.

Бид, Энэтхэг-Хятадын хилийн тухай зохих
 хүмүүс болон, зохих улс, зохих оронд танилцуулж
 тайлбарлах ажлыг нилээд хийсэн юм. Энэтхэгийн
 зүгээс биднийг биеэ барьж байхын аргагүй бай-
 далд оруулсан. Бид аргагүй арга хэмжээ авахад
 хүрлээ. Энэтхэг шинэ түрэлтийг хийж, мөргөлдөө-
 нийг өдөөсөн юм. Ийм ноцтой байдалд хүргэсэн
 болохоор бид хариу цохилтыг Энэтхэгт өгдөө.
 Бид хурцадмал байдлыг намжаах арга хэмжээ
 авлаа. Гал зогсоож, цэргээ татлаа. Энэ бол нэг
 талын арга хэмжээ юм. Уул асуудал эцэс болон
 шийдвэрлэгдэх баталгаагүй байна. Энэтхэгийн
 засгийн газрын эрх баригчдын түрэмгий бодлогоос
 л хэрэг үүсч байна. Неругийн засгийн газар
 төвийг сахих бодлогоос ухарч зуйвах байдалд
 орж байна. Энэтхэг цэргийн түрэмгий эвсэл холбоонд
 орохгүй гэсэн мөртлөө Америкийн долларын нөлөөнд
 автагдан орж байна.

Энэтхэг Америкаас 640 сая долларын тусламжийг
 авчээ. Түүнийгээ цэрэг дайны хэрэгт зориулан
 зарцуулж байна.

Ийнхүү Неругийн засгийн газар энх тайвны
 бодлогоос ухарч байна. империализмын гай аюулыг
 ойлгох л хэрэгтэй юм. Энэтхэгийн дотоодын харгис
 хүчин идэвхжиж байна. Энэтхэг энх тайвны бодло-
 гоос ухарч байна. Харин манай тал гал зогсоож
 хэлэлцээ эхлэхийг санаачлан тавьж байна.

- 39 -

16

Энэтхэгийн засгийн газар манай тавьсан санал, авсан арга хэмжээнд харну өгөөгүй байна. Ийм үед Танаас Энэтхэг-Хятадын харилцааны тухай асуудлыг зөв ойлгохыг хүсэж байна.

БНМАУ НҮБ-ын гишүүн болсон билээ. Тэхлээр танайд байдал ойлгомжтой байх ёстой. НҮБ-д суугаа Энэтхэгийн төлөөлөгч Өрнөдийн орнуудын бодлогыг дагаж байна. Унгар, Солонгос, Хятадын болон зөвсэглэлийг хураах асуудлын хувьд Өрнөдийн орнуудын бодлогыг Энэтхэг дэмжин дагаж байна. Энэтхэг ийм замаар жоригс хөрөнгөтний талд гүнээр живэн орж байна.

Нөхөр Цэдэнбал Та миний ярьж буй зарим зүйлийг зөвшөөрөх байх, заримыг зөвшөөрөхгүй байх. Би Таныг миний саналыг хүлээж ав гэж байгаа хэрэг биш, үнэн мөнгийг цаашдын хөгжил харуулна. Манай бодлого бол марксизм-ленинизмын зарчмыг удирдлага болгосон энх тайванч гадаад бодлого юм.

Цэдэнбал- Бидний гол ажил бол Монгол-Хятадын хилийн гэрээнд үсэг зурах явдал юм. Энэ ажил маань амжилттай дуусч байна.

Дэлхийн энх тайвныг хамгаалах хэрэгт Зөвлөлт Холбоот Улс, БНХАУ болон социалист лагерийн орнууд чухал ач холбогдолтой байна л даа. Социалист улсууд өөрийн чадах хирээрээ энх тайвны төлөө тэмцэлд хувь нэмрээ оруулах зорилготой. Энэтхэг-Хятадын хилийн будлианыг энх тайвны замаар шийд-
+ вэрлэхийг социалист орнууд зүй ёсоор сонирхож байгаа юм. Үүнтэй холбогдуулан Та бид хоёр ярьж байна гэж би ойлгож байна.

Неру бол коммунист биш, хөрөнгөтний зүтгэлтэн гэдгийг Та бид адилхан мэднэ. Гэхдээ хөрөнгөтний

зүтгэлтнүүдийн дотроос тэдний ашигтай үйл ажиллагааг нийт социалист лагерийн ашиг тусын тулд ашиглах нь чухал гэдгийг Та бид мөн ойлгож байна. Дайсагнах талын тийм зарим хүмүүсийн үйл ажиллагааг ашиглах талаар таний нам, олон жилийн түүхэндээ их туршлага хуримтлуулсан гэдгийг бид мэдэж байна.

Энэтхэгийн төвийг сахих бодлогыг ашиглах нь манай социалист лагерьт их ач холбогдолтой байна. Ерөнхий сайд н. Чжоу Энъ-лай Та Нерутай хамтран тунхагласан зэрэгцэн орших таван зарчмыг үүнд чиглэсэн зүйл гэж үзвэл зохих юм. Хэрэв Неругийн оронд Десай шиг хүн засгийн эрхэнд орвол байдал манай лагерьт улам ашиггүй болох байх аа. Тэгвэл Энэтхэг т, рэмгий эвсэлд ч орох аюул гарч болох юм. Ер нь төвийг сахих байдалд Энэтхэгийг хэвээр үлдээж, үүнийг ашиглах явдал ач холбогдолтой гэж бид үзэж байна. Та бүхэн ч тэгж бодож байгаа байх гэж санагдах юм. Одоогийн олон улсын харилцааны байдалд орон нутгийн чанартай зүйл ч гэсэн цууриатай болдог болохоор Хятад-Энэтхэгийн хилийн будлианы асуудал ч дэлгэр яригдаж байх юм.

Энэ будлианыг дэлхийн асуудалтай холбон үзэж, бүх нарийн төвөгтэй асуудлыг харгалзан танайх галаа зогсоогоод цэргээ татаж, хэлэлцээн ний журмаар уг асуудлыг шийдэх гэж байгаа явдал бол социалист лагерийн ард түмэн, нийт шудрага хүн төрөлхтний ашиг сонирхолд тохирч байна гэж бид үзэж байна.

Чжоу Энъ-лай-Неругийн засгийн газар бол том хөрөнгөтний төлөөлөгч бөгөөд хоёр нүүртэй байгаад асуудлын гол нь оршино. Энэ тайвны тэмцэлд хөрөнгөтнийг ч

-34-

18

ашиглах гэдэг нь зүйтэй. Гэвч Неру бол хөрөнгө-
төний том төлөөлөгч юм. Неругийн засгийн газрын
үйл ажиллагаа нь харгис талдаа шилжин оржээ.
Түүний эсрэг шийдвэртэй тэмцэх нь чухал байна.
Түүний хуурамч заль мэхийг илрүүлэх хэрэгтэй.
Америкийг түшиглэх боддлогын хувьд Неру бол
Десайгаас ялгаагүй хүн юм.

Хэлэлцээг сэргээх аргаар энх тайвныг бэх-
жүүлэхэд бид ашигтай зүйлийг ашиглана. Гэхдээ
энэ асуудлын хувьд коммунистууд буюу зарим
хүмүүс ондоогсоор үзэж байна. Английн коммунист
нам бусад асуудлын талаар бидэнтэй ~~бодвол~~ ^{Нийлмэл үзэл}.
Гэтэл Энэтхэг-Хятадын хилийн тухай асуудлаар
бидэнтэй санал нийлж байна. Та цаашид үүнийг
бодвол сайн.

Цэдэнбал- Хилийн зүүн хэсгийн 90 000 хавтгай дөрвөлжин
км газрыг хятадын тал заавал одоо авна гээгүй.
ирээдүйд шийдэх асуудал гэж би ойлгож байна.
Энэ зөв үү?, буруу юу?

Чжоу Энъ-лай-Хятад-Энэтхэгийн хилийн асуудлыг шийдвэрлэхээр
би нөхөр Чэнь И-тэй 1960 онд Энэтхэгт очсон
боловч үр дүнгүй буцаж ирсэн юм.

Цэдэнбал-Хятад-Энэтхэгийн хилийн асуудлыг шийдвэрлэхдээ
гагцхүү хятадын ашиг тусын үүднээс биш, мөн
дэлхийн коммунист хөдөлгөөний ашиг сонирхолтой
уялдуулан шийдвэрлэх нь зүйтэй юм.

Энэ талаас үзэхэд зүүн талын 90 000 хавтгай
дөрвөлжин км газрын тухай асуудал ирээдүйд
шийдвэрлэгдэх юм гэдгийг дотроо бодоод, түүнийг
одоо сөхөж тавихгүй, харин Энэтхэгийн дотоодын
ангийн тэмцлийг социализм, коммунизмд ашигтай-
гаар хөгжүүлэхэд туслаж, Энэтхэгийн коммунист
намыг бэхжүүлэх, ардчилсан хүчийг нь бэхжүүлэх,

-331-

19

үүгээрээ Энэтхэг социализмд орох цагийг ойртуулахад туслах явдал арай дээр юм гэж би хувьдаа бодож байна. Хилийн асуудал ирээдүйд шийдвэрлэгдэх нь зайлшгүй. Энэтхэгийн коммунист намын хүчийг сулруулах, буруулах гэж та нөхдийг бодож байгаа хэрэг гэж огт үзээгүй байна.

Коммунист хүмүүс ийм санаатай байна гэж бодвол инээдэмтэй хэрэг болно. Энд тэнд 5, 10 км газрын төлөө булаацалдаж, маргаж шуугиад байх тусам яван явсаар Энэтхэгийн дотоодын харгис хүч үндсэрхэх үзлийг улам хүчтэй болгож хөгжүүлээд улмаар коммунистуудад муугаар нөлөөлөх бөгөөл энэ нь социализмд ашиггүй болох юм. Хятадын коммунистууд Та бүхэн бол биднээс илүү их туршлагатай, хувьсгалт тэмцэлд хатуужсан хүмүүс билээ. Би зөвхөн өөрийн ойлгож байгаа, санаж бодсон зүйлээ ярьж байна.

Чжоу Энх-лай-/Нилээд уурлаж хилэгнэх байдалтай царайгаа хувиргаж/ хэлсэн нь: Хэрэв Та Энэтхэг-Хятадын хилийн асуудлын талаар сонирхож байгаа бол Ази Африкийн орнуудад явуулсан манай захидлыг дахин судалж үзэхийг нөхөр Цэдэнбал Танд хүсье. Манай засгийн газар Энэтхэгтэй хэдэн арван км талбайн хувьд маргаж байгаа биш, бид нутаг дэвсгэрийн шаардалга тавиагүй, Энэтхэгийн тал л ийм шаардлага тавьж байна. Үүнийг зөв ойлгох хэрэгтэй. Харин Энэтхэг түрэмгий зан гаргаад болохгүй байна. Асуудлын гол бол Энэтхэгийн тал хилийн баруун хэсэгт байгаа нутгаас бас нэмж их талбайтай нутаг авах гэж байгаад оршино. Тэхдээ аль болохоор Энэтхэгийг социализмд түргэн оруулах нь юуны өмнө Энэтхэгийн коммунист нам, Энэтхэгийн ард түмний хувьсгалт тэмцлээс шалтгаалах ёстой. Харин Энэтхэгийн харгис хүчний хуурамч заль мэх,

-34-

20

түүний хор аюулыг дэлхийн олон нийтэд илчлэх нь чухал юм. Тэдний харгис Үйл ажиллагааг илчлэхгүй бол тэд Америкийн талд орох бөгөөд улам ашиггүй болно.

Цэдэнбал - Гол нь Америкийн империализмд л ашиглуулахгүй байх нь чухал.

Дараагийн программт ажлын цаг тулгарсан учир яриаг маргааш нь үргэлжлүүлэхээр тохиролцов.

ТЭМДЭГЛЭЛИЙГ
ҮЙЛДСЭН

Агван С. БАТАА
Д. ЧИМЭДДОРЖ

1962-12-29.

НИЙЛСЭН _____
001,3 хувь, 297238